

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-/52/2023-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Нэхим туудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.09.25 № 01/138
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЦЭРЭННАДМИД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баянжаргалан сумын 100 жилийн ой 2023 онд болохтой холбоотой бэлтгэл ажлууд хийгдэж эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Сумын 100 жилийн ойг угтан 20,000.0 мянган төгрөгийн хандивыг нэмэлт санхүүжилтийн дансанд авч зарцуулсан байна.
- Нутгийн зөвлөлийн уулзалт зохион байгуулахад 4,815.0 мянган төгрөгийг ресторан, хүлээн авалтад зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

G/Arkhip/Alban bichig 2023/ A4
19020245

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	38,984,987	144,783,388
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	200	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	200	-
3121	Төгрөг	200	-
31213	Аригжааны банк дахь харилцах	200	-
33	АВЛАГА	1,900,000	2,300,000
335	Бусад авлага	1,900,000	2,300,000
3351	Байгууллагаас авах авлага	200,000	200,000
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,700,000	2,100,000
35	БАРАА МАТЕРИАЛ	37,084,787	142,483,388
354	Хангамжийн материал	35,214,787	140,613,388
35410	Бичиг хэргийн материал	2,256,850	2,643,050
35420	Аж ахуйн материал	15,744,180	17,032,396
35430	Сэлбэг хэрэгсэл	2,308,000	114,268,226
35440	Түлш, шатах тослох материал	1,405,757	-
35470	Бусад хангамжийн материал	13,500,000	6,669,716
35600	Мал амьтад	1,870,000	1,870,000
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	922,020,583	1,036,614,007
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	922,020,583	1,036,614,007
392	Биет хөрөнгө	837,368,583	952,112,007
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,129,404,929	1,294,876,984
39202	Хуримтлагдсан элэгдэл	(366,882,087)	(438,596,769)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	95,868,255	154,677,345
39204	Хуримтлагдсан элэгдэл	(69,609,921)	(90,918,255)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	66,669,118	71,238,218
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,572,244)	(46,684,262)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,878,371	22,878,371
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,387,837)	(15,359,625)
393	Биет бус хөрөнгө	84,652,000	84,502,000
39301	Програм хангамж	1,080,000	1,080,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000)	(600,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	84,022,000	84,022,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	961,005,570	1,181,397,395
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	400,000
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	400,000
413	Өглөг	-	400,000
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	400,000

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	961,005,570	1,180,997,395
51	Засгийн газрын хувь оролцоо	961,005,570	1,180,997,395
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	719,419,323	719,419,323
51101	Өмч: - төрийн	719,419,323	719,419,323
512	Хуримтлагдсан үр дүн	11,030,072	231,021,897
51210	Өмнөх үеийн үр дүн	69,107,814	11,030,072
51220	Тайлант үеийн үр дүн	(58,077,743)	219,991,825
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,556,175	230,556,175
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	961,005,570	1,181,397,395

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	430,510,318.68	744,756,338.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,276,840.00	335,369,771.00
120	Нийтлэг татварын бус орлого	31,276,840.00	335,369,771.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,276,640.00	335,369,771.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,276,640.00	335,369,771.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	399,233,478.68	409,386,567.16
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,133,166.27	50,858,488.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,571,185.00	6,027,611.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,561,981.27	44,830,877.64
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	328,100,312.41	358,528,078.52
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,100,312.41	358,528,078.52
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	486,754,728.23	524,764,512.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	486,754,728.23	524,764,512.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,827,308.79	487,807,495.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,662,396.30	196,548,047.31
210101	Үндсэн цалин	136,178,568.28	153,550,216.82
210102	Нэмэгдэл	48,130,321.03	32,688,021.81
210104	Урамшуулал	-	10,309,808.68
210105	Гэрээт ажлын хөлс	36,353,506.99	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,172,500.00	26,849,871.18
210201	Тэтгэврийн даатгал	21,939,300.00	19,232,871.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,309,400.00	1,904,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,842,900.00	1,522,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	462,000.00	381,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,618,900.00	3,808,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,267,265.45	34,770,784.03
210301	Гэрэл, цахилгаан	3,315,555.00	3,905,048.00
210302	Түлш, халаалт	27,257,157.45	27,383,163.03
210303	Цэвэр, бохир ус	4,694,553.00	3,482,573.00

2104	Хангамж, бараа материалын зардал	22,888,548.86	30,872,159.00
210401	Бичиг хэрэг	3,643,088.86	4,793,500.00
210402	Тээвэр, шатахуун	12,814,010.00	18,341,975.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	7,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,547,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,431,450.00	5,181,884.00
2105	Нормативт зардал	2,990,750.00	7,350,750.00
210502	Хоол, хүнс	2,990,750.00	7,350,750.00
2107	Томилолт, зочны зардал	1,222,500.00	4,789,200.00
210702	Дотоод албан томилолт	1,222,500.00	4,789,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,224,792.00	38,630,016.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,968,032.00	37,556,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	651,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	183,700.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	312,060.00	373,316.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,398,556.18	147,996,667.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,358,297.63	33,739,846.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,040,258.55	114,256,820.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,927,419.44	36,957,017.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,182,400.00	24,928,513.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	23,792,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,182,400.00	136,413.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,745,019.44	7.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,745,019.44	7.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	12,028,497.64
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	12,028,497.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(56,244,409.55)	219,991,825.49
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,833,333.05	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,833,333.05	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,833,333.05)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(58,077,742.60)	219,991,825.49

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	399,233,478.68	409,386,567.16
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	399,233,478.68	409,386,567.16
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,133,166.27	50,858,488.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,571,185.00	6,027,611.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,561,981.27	44,830,877.64
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	328,100,312.41	358,528,078.52
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,100,312.41	358,528,078.52

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	397,463,678.68	408,087,667.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	397,463,678.68	408,087,667.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,536,259.24	370,350,769.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,662,396.30	196,548,047.31
210101	Үндсэн цалин	136,178,568.28	153,550,216.82
210102	Нэмэгдэл	48,130,321.03	32,688,021.81
210104	Урамшуулал	-	10,309,808.68
210105	Гэрээт ажлын хөлс	36,353,506.99	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,172,500.00	26,849,871.18
210201	Тэтгэврийн даатгал	21,939,300.00	19,232,871.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,309,400.00	1,904,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,842,900.00	1,522,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	462,000.00	381,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,618,900.00	3,808,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,267,265.45	34,770,784.03
210301	Гэрэл, цахилгаан	2,918,312.45	3,905,048.00
210302	Түлш, халаалт	27,654,400.00	27,383,163.03
210303	Цэвэр, бохир ус	4,694,553.00	3,482,573.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,334,488.86	17,121,486.00
210401	Бичиг хэрэг	2,997,088.86	1,350,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,851,300.00	11,234,786.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,086,100.00	1,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	3,236,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	3,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,222,500.00	4,789,200.00
210702	Дотоод албан томилолт	1,222,500.00	4,789,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,865,129.00	38,630,016.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,608,369.00	37,556,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	651,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	183,700.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	312,060.00	373,316.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,511,979.63	50,141,365.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,511,979.63	50,037,365.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,927,419.44	37,736,897.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,182,400.00	25,708,393.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	23,792,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,182,400.00	916,293.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,745,019.44	7.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,745,019.44	7.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	12,028,497.64
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	12,028,497.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,769,800.00	1,298,900.00

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,769,800.00	1,299,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,769,800.00	1,299,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,769,800.00	1,299,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,769,800.00	1,299,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,769,800.00)	(1,299,100.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	(200.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	200.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	200.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	719,419,322.53	231,527,566.75	68,136,422.85	0.00	1,019,083,312.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	971,391.54	0.00	971,391.54
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	719,419,322.53	231,527,566.75	69,107,814.39	0.00	1,020,054,703.67
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-971,391.54	0.00	0.00	-971,391.54
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-58,077,742.60	0.00	-58,077,742.60
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	719,419,322.53	230,556,175.21	11,030,071.79	0.00	961,005,569.53
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	719,419,322.53	230,556,175.21	11,030,071.79	0.00	961,005,569.53
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	719,419,322.53	230,556,175.21	11,030,071.79	0.00	961,005,569.53
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	219,991,825.49	0.00	219,991,825.49
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	719,419,322.53	230,556,175.21	231,021,897.28	0.00	1,180,997,395.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	378,361,900.00	358,528,071.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,361,900.00	358,528,071.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	352,570,200.00	332,819,678.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,982,700.00	196,548,047.31
210101	Үндсэн цалин	162,441,000.00	153,550,216.82
210102	Нэмэгдэл	42,541,700.00	32,688,021.81
210104	Урамшуулал	-	10,309,808.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,672,700.00	26,849,871.18
210201	Тэтгэврийн даатгал	19,473,400.00	19,232,871.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,049,900.00	1,904,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,639,800.00	1,522,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	410,000.00	381,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,099,600.00	3,808,500.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,294,900.00	31,288,211.03
210301	Гэрэл, цахилгаан	2,949,000.00	3,905,048.00
210302	Түлш, халаалт	28,345,900.00	27,383,163.03
2104	Хангамж, бараа материалын зардал	16,031,300.00	15,738,000.00
210401	Бичиг хэрэг	1,350,000.00	1,350,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,851,300.00	9,851,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,300,000.00	1,300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,530,000.00	3,236,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,789,200.00	4,789,200.00
210702	Дотоод албан томилолт	4,789,200.00	4,789,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,611,400.00	38,630,016.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,516,100.00	37,556,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,044,700.00	373,316.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	350,600.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,688,000.00	17,476,333.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,688,000.00	17,476,333.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,791,700.00	25,708,393.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,791,700.00	25,708,393.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,792,100.00	23,792,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	999,600.00	916,293.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	364,992,970.00	358,528,078.52
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	364,992,970.00	358,528,078.52
122005	Орон нутгийн төсвөөс	364,992,970.00	358,528,078.52

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,446,438.63	38,829,991.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,446,438.63	38,829,991.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,264,038.63	38,829,991.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,536,553.00	3,482,573.00
210303	Цэвэр, бохир ус	4,536,553.00	3,482,573.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,383,486.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,383,486.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	625,306.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	625,306.00	

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,102,179.63	33,963,932.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,102,179.63	33,859,932.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,182,400.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,182,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,182,400.00	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,686,727.64	12,028,497.64
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	10,686,727.64	9,412,400.34
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,616,097.30
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	71,133,166.27	50,858,488.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,133,166.27	50,858,488.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,571,185.00	6,027,611.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,561,981.27	44,830,877.64

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газар нь сумын Засаг даргын бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- Нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 12 зорилт, хэрэгжүүлэх 38 арга хэмжээтэй баталснаас нийт 93,8 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газарт дотоод аудитын нэгж байхгүй ба Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Тамгын газрын даргын 2021 оны А/18 дугаар тушаалаар дотоод хяналт, шалгалтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталж Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газарт аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албаас 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 33,136.2 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 1,336.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгөгдсөн байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагад өдөр тутам мөрдөгддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 220,391.8 мянган төгрөгөөр буюу 23,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.2	0.0	-0.2
Авлага	1,900.0	2,300.0	400.0
Бараа материал	37,084.7	142,483.3	105,398.6
Үндсэн хөрөнгө	922,020.5	1,036,614.0	114,493.5
Нийт хөрөнгө	961,005.5	1,181,397.3	220,391.8
Өр төлбөр	0.0	400.0	400.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	961,005.5	1,180,997.3	219,991.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	961,005.5	1,181,397.3	220,391.8

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага данс 400.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Бараа материал дансны эхний үлдэгдэл 37,084.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 142,483.3 мянган төгрөг болж 105,398.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалтай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 922,020.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,036,614.0 мянган төгрөг болж, 114,493.5 мянган төгрөгөөр өссөн нь нэмэгдсэн болон хасагдсан үндсэн хөрөнгөөс гадна элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,180,997.3 мянган төгрөг болж 219,991.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Авлага, өглөгийн данс 400.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ажилчдаас суутгаж авч төсөвт төлөх актын төлбөртэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 348,940.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 9,734.0 мянган төгрөгөөр бууруулан 2022 оны урсгал зардлын төсвийг 358,674.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 358,674.3 мянган төгрөгөөс 1 удаа тодотгол хийж 358,528.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2

хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 358,528.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч бүрэн зарцуулсан байна. Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 358,528.0 мянган төгрөг буюу 100.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	243,701.3	243,701.3	0.0	100.0%
2	70106/80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	39,574.7	39,574.7	0.0	100.0%
3	70106/80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	36,306.9	36,306.9	0.0	100.0%
4	70106/80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	25,708.3	25,708.3	0.0	100.0%
5	70106/81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0.0	100.0%
6	71411/82801 Хур хог хаягдал, орчны бохирдлыг	5,000.0	5,000.0	0.0	100.0%
	71411/82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг	3,236.7	3,236.7	0.0	100.0%
	ДҮН	358,528.0	358,528.0	0.0	100.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд өвс тэжээлийн орлого 21,229.9 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын гэрээ, хандиваар 20,000.0 мянган төгрөг, ус, картын орлого 4,923.5 мянган төгрөг, дээд газраас шилжиж орж ирсэн 3,297.6 мянган төгрөг, хог хаягдлын хураамж 1,168.8 мянган төгрөг, 2021 оны ковид цар тахлын хандив 238.6 мянган төгрөг нийт 50,858.4 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүнээс худгийн ажилтны урамшуулалд 3,482.5 мянган төгрөг, шатахуунд 462.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 34,781.3 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 104.0 мянган төгрөг нийт 38,830.0 мянган төгрөгийг зарцуулж 12,028.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хөтөлбөр 93.8 %	358,528.0	358,528.0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны 06/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын батлагдсан 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 430,510.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 6,457.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,843.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 1,147, хугацаа хоцроосон 24 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 4 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 2 зөрчил нь арилсан, 2 зөрчил арилаагүй байсан тул уг 2 зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	2,184.6	1	2,184.6	100%
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100%
Нийт дүн	2	2,184.6	2	2,184.6	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянжаргалан сумын 100 жилийн ой 2023 онд болохтой холбогдуулан хандивын орлого, зардлуудын талаар авч үзэх нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийгдээгүй болно.

5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт бичигдээгүй болно.

5.3 Албан шаардлага

1. Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим төлбөрийн баримттай тулгалт хийхэд цахим баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 7,535.7 мянган төгрөгөөр дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ", санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

2. Сумын 100 жилийн ойг угтан 20,000.0 мянган төгрөгийн хандивыг нэмэлт санхүүжилтийн дансанд авч зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д "Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно", 25.5.1-д "Хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх", 25.5.2-д "Байгууллагын ажилтны энэ хуулийн 25.4.2-т зааснаас бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой байх" гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

3. Тус байгууллага нь нутгийн зөвлөлийн уулзалт зохион байгуулахад 4,815.0 мянган төгрөгийг ресторан, хүлээн авалтад зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д "Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд кассаар нийт 11,981.5 мянган төгрөгийг бэлнээр гаргаж зарцуулсан байна. Үүнд: автомашины засвар, баяр наадмын зардал, бараа материал худалдан авах зардлууд байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 6.3-д заасан “Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ-500,000(таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бэлэн мөнгө гаргахаас зайлсхийх, бараа материал худалдан авахад харилцах дансаар гүйлгээг хийх.

2. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Усны орлого 720.5 мянган төгрөгийг сумын орлогын дансанд төвлөрүүлэлгүй нэмэлт санхүүжилтийн дансанд авч зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8-д “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.8.9-д “хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр” гэсэн заалт, Санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Усны орлогыг сумын татварын орлогын ус, рашааны төлбөр дансанд төвлөрүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим баримт, хандив, төрийн хэмнэлтийн хууль	5	45,052.7			3	35,350.7	2	12,702.0				
Дүн	5	45,052.7			3	35,350.7	2	12,702.0				